

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: ОРА-2025/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Эрдэнэт хот
2025 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088, Цахим хаяг: purevkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805, Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Аудитор: Б.Азжаргал
Утас: 70357955, Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2025.03.14 № 93
танай _____-ны № _____-т

ЭРДЭНЭТ ШИНЖЛЭХ УХААН,
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨҮГ-ИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 45 дугаар хуралдааны шийдвэрээр 2024 оны бизнес төлөвлөгөөнд орлого 302.8 сая төгрөг, зардал 301.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд 2,900.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч хөрөнгөд бүртгэсэн байна.

Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ-ын 2024 оны аймгийн Засаг даргатай 1 зорилго, 3 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 82.0 хувьтай гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

№	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2023.12.31	2024.12.31
А	Б	1	2
1.1.1	Мөнгөн хөрөнгө	11,359,702.93	1,481,150.38
1.1.2	Дансны авлага	192,600,000.00	190,900,000
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	17,142.95	0
1.1.4	Бусад авлага	618,772,000.00	516,163,585.37
1.1.6	Бараа материал	1,037,575,336.20	3,937,600,428.26
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,860,324,182.08	4,646,145,164.01
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,835,408,619.39	1,889,396,003.41
1.2.2	Барилга байгууламж орон сууц	1,483,098,090.00	1,035,303,790
1.2.3	Хуримтлагдсан элэгдэл	-98,235,521.07	-99,216,356.58
1.2.4	Авто тээврийн хэрэгсэл	35,000,000.00	56,900,500
1.2.5	Хуримтлагдсан элэгдэл	-18,958,332.93	-26,674,362.04
1.2.6	Машин тоног төрхөөрөмж /компьютер/	723,869,024.72	1,381,940,324.72
1.2.7	Хуримтлагдсан элэгдэл	-320,997,130.78	-484,004,546.26
1.2.8	Тавилга эд хогшил	66,021,036.36	66,021,036.36
1.2.9	Хуримтлагдсан элэгдэл	-34,388,546.91	-40,834,382.79
1.2.2	Биет бус хөрөнгө	863,080,000.00	1,716,757,246.90
1.2.3	Биет бус хөрөнгө программ хангамж	865,800,000.00	2,613,525,037.02
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	-2,720,000.00	-896,767,790.12
1.2.5	Урт хугацаат хөрөнгө оруулалт	100,000,000.00	100,000,000.00
1.1.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	250,000,000.00	250,000,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,048,488,619.39	3,956,153,250.31
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,908,812,801.47	8,602,298,414.32
2.1.1.1	Дансны өглөг	761,850,000.00	702,737,764.20
2.1.1.3	Татварын өр	985,541.55	17,946,944.66
2.1.1.12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	762,835,541.55	720,684,708.86
2.3.1	Өмч: а) төрийн	1,150,103,063.75	9,538,370,420.09
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	3,445,244,610.00	00
2.3.9	Хуримтлагдсан ашиг, алдагдал	-449,370,413.83	-1,656,756,714.64
2.3.12	Эздийн өмчийн дүн	4,145,977,259.92	7,881,613,705.46
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,908,812,801.47	8,602,298,414.32

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

№	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
---	----------	------------	------------

A	Б	2023.12.31	2024.12.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	246,414,472.09	182,611,193.45
2	Борлуулалтын өртөг	18,343,911.98	0
3	Нийт ашиг (алдагдал)	228,070,560.11	182,611,193.45
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	20,000,000.00	5,000,000.00
7	Борлуулалт, маркетингийн зардал	35,266,940.12	39,814,704.31
8	Ерөнхий ба удирдлагын зардал	390,813,066.70	1,338,066,325.86
9	Санхүүгийн зардал	1,800,000.00	-
10	Бусад зардал	141,882,136.42	17,116,464.08
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	- 321,691,583.13	-1,207,386,300.80
12	Орлогын татварын зардал	-	-
13	Татварын дараах ашиг (алдагдал)	- 321,691,583.13	-1,207,386,300.80
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	- 321,691,583.13	-1,207,386,300.80
15	Орлогын нийт дүн	- 321,691,583.13	-1,207,386,300.80
16	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,595,347,673.75	-449,370,413.83	4,145,977,259.83
2	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	4,595,347,673.75	-449,370,413.83	4,145,977,259.83
4	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,595,347,637.75	-449,370,413.83	4,145,977,259.92
5	Тайлангийн үеийн цэвэр ашиг	-	-1,207,386,300.80	-1,207,386,300.80
6	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	4,943,022,746.34	-	4,943,022,746.34
8	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,538,370,420.09	- 1,656,756,714.64	7,881,613,705.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

№	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
A	Б	1	2
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	449,739,507.45	202,572,277.90
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	177,469,507.45	202,572,277.90
1.1.6	Бусад мөнгөн орлого	272,270,000.00	0
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	591,675,237.66	
1.2.1	Ажиллагчдад олгосон мөнгө	63,011,442.19	115,422,051.37

1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	18,472,774.47	33,503,730.05
1.2.3	Түүхий эд материал худалдан авахад төлсөн мөнгө	21,946,697.91	12,828,180.35
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	30,791,988.03	26,494,501.65
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	10,338,838.18	6,699,408.18
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	18,871,526.44	14,302,738.18
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	428,241,970.44	57,310,835.67
1.2.9	Бусад мөнгөн зарлага	428,241,970.44	57,310,835.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-141,935,730.21	-63,989,167.55
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,000,000.00	5,000,000.00
2.1.6	Хүлээн авсан ногдол ашиг	20,000,000.00	5,000,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	23,454,454.55	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	23,454,454.55	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-3,454,454.55	5,000,000.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	116,201,000.00	108,495,415.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	116,201,000.00	108,495,415.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	165,000,000.00	59,384,800.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	165,000,000.00	59,384,800.00
3.2.5	Бусад зарлага	165,000,000.00	59,384,800.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-48,799,000.00	49,110,615.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-194,189,184.76	-478,552.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	205,548,887.69	11,359,702.93
6	Мөнгөн, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	11,359,702.93	1,148,150.38

2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

№	Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Менежементийн орлого	33,000,000	37,042,027	112%
2	Бизнес хөгжлийн төвийн зардал	98,830,000	98,830,000	100%
3	Ноогдол ашиг	40,000,000	5,000,000	13%
4	Цахим-Эрдэнэт төслийн нэгжийн зардал	65,000,000	65,000,000	100%
5	Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт	65,957,000	29,395,665	45%
Нийт дүн		302,787,000	235,267,692	78%
№	Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	биелэлт
1	Хөдөлмөрийн зардал	179,010,000	154,979,853	78%
2	Эрчим хүч	26,450,000	22,850,855	86%
3	Холбоо мэдээлэл	19,244,000	19,763,937	103%
4	Санхүү программ лиценз	440,000	440,000	100%
5	Газрын төлбөр	3,680,000	400,000	11%

6	Бусдаар гүйцэтгүүлэх ажлын зардал	38.300.000	35,361,065	92%
7	Томилолт	6.000.000	5,998,475	100%
8	Бичиг хэрэг	1.200.000	1,290,265	108%
9	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	3.400.000	3,390,650	100%
10	Цэвэрлэгээ ариутгалын материал	600.000	739,550	123%
11	Барилгын материал	7.600.000	7,582,900	100%
12	Шатахуун	2.400.000	2,341,659	98%
13	Байгаль орчныг хамгаалах	1,000,000	954,700	95%
14	Ажилтны тэтгэмж, ахмадын сан	2,300,000	2,300,000	100%
15	Эвент арга хэмжээ	8,800,000	8,773,850	100%
16	Бусад	1,200.000	1,184,450	99%
Нийт		301,624.000.00	268,352,244.00	80.50%

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 45 дугаар хуралдааны шийдвэрээр 2024 оны бизнес төлөвлөгөөг баталсан.

Тайлант онд орлогыг 302.8 сая төгрөгөөр, зардлыг 301.6 сая төгрөгөөр, 1.2 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

Орлогын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Менежментийн орлого	33,000,000	37,042,027	112%
Бизнес хөгжлийн төвийн урсгал зардал	98,830,000	98,830,000	100%
Ноогдол ашиг	40,000,000	5,000,000	13%
Цахим Эрдэнэт төслийн нэгжийн зардал	65,000,000	65,000,000	100%
Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт	65,957,000	29,395,665	45%
Нийт	302,787,000	235,267,692	78%

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Хөдөлмөр	179,010,000	154,979,853	87%
Эрчим хүч	26,450,000	22,850,855	86%
Холбоо, мэдээлэл	19,244,000	19,763,937	103%
Санхүү програмын лиценз	440,000	440,000	100%
Газрын төлбөр	3,680,000	400,000	11%
Бусдаар	38,300,000	35,361,065	92%
Томилолт	6,000,000	5,998,475	100%
Бичиг хэрэг	1,200,000	1,290,265	108%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	3,400,000	3,390,650	100%
Цэвэрлэгээний материал	600,000	739,550	123%
Барилгын материал	7,600,000	7,582,900	100%

Шатахуун	2,400,000	2,341,659	98%
Байгаль орчныг хамгаалах	1,000,000	954,700	95%
Ажилтны тэтгэмж, ахмад сан	2,300,000	2,300,000	100%
Эвент, арга хэмжээ	8,800,000	8,773,885	100%
Бусад	1,200,000	1,184,450	99%
Нийт	301,624,000	268,352,244	80.5%

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 74.2 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 3.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 71.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 алдаанд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Анхан шатны баримтгүй томилолтын зардалд 3,041.0 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 3.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд ажилд томилох тушаал шийдвэр гаргалгүй, хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй 18 хүн ажилд авч 71,258.0 мянган төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 4.1.15-д ""хөдөлмөр эрхлэлтийн харилцаа" гэж ажилтан нь ажил олгогчийн удирдлага, заавар, хяналтын доор тодорхой ажил үүргийг энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд ажил олгогчийн заасан ажлын байранд биечлэн гүйцэтгэх, ажил олгогч нь ажилтанд цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлөөр хангах талаар харилцан эрх эдэлж, үүрэг хүлээхээр тохиролцсоноор үүссэн харилцааг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалд тооллого хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-д "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана: 1/үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/; 2/ түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай хийж гүйцэтгэх, үр дүнг өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэх хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах.

Илрүүлэлт: Барилга байгууламж, автомашин, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийн хувийн хэрэг хөтлөөгүй, тайлант онд гарсан өөрчлөлтийг хувийн хэрэгт тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар", Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 180 дугаар тушаалаар баталсан Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа, ажил, үйлчилгээний анхан шатны баримтыг холбогдох хууль, журамд нийцүүлж, бүртгэж тайлагнах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨҮГ	4	74.2	1	3.0	1	71.2	2	0	-	-	-	-
Дүн	4	74.2	1	3.0	1	71.2	2	0				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨААН	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

